



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн 4 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2022/65/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Эрдэнэт хот

2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ц.Нармандах

Утас: 70359826 Цахим хаяг: orkhon@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ

Утас: 70355805 Цахим хаяг: orkhon@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Буян-Ундрах

Утас: 70357955 Цахим хаяг: orkhon@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	12
3.8 Аудитын гол асуудал	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	13
4. Аудитын илрүүлэлт	13
4.1 Залруулсан алдаа.....	13
4.2 Төлбөрийн акт	13
4.3 Зөвлөмж.....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.Аудитын санал дүгнэлт



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2021.02.25 № 93
танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМГИЙН 4 ДҮГЭЭР
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Ц.БОЛДСУХ ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн 4 дүгээр сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн 4 дүгээр сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

D:\my doc \alban bichig\ 2022-A4.doc

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

ДАНС	Үзүүлэлт	Үлдэгдэл	ГҮЙЦЭТГЭЛ
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	256,593,411.63	250,208,016.05
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	854,400.00	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	854,400.00	-
3121	Төгрөг	854,400.00	-
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	854,400.00	-
33	АВЛАГА	6,940,674.94	11,408,114.94
335	Бусад авлага	6,940,674.94	11,408,114.94
3351	Байгууллагаас авах авлага	6,940,674.94	11,987,518.58
35	БАРАА МАТЕРИАЛ	248,798,336.69	238,799,901.11
351	Түүхий эд материал	132,628,442.81	128,179,540.13
35110	Тусгай зориулалттай материал	132,493,542.81	128,107,790.13
35130	Эм боох материал	134,900.00	71,750.00
354	Хангамжийн материал	116,169,893.88	110,620,360.98
35420	Аж ахуйн материал	5,461,948.00	2,856,334.00
35470	Бусад хангамжийн материал	110,707,945.88	107,764,026.98
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,721,930,505.51	5,552,105,060.57
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,721,930,505.51	5,552,105,060.57
392	Биет хөрөнгө	4,925,010,505.51	4,757,735,060.57
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,027,254,851.22	5,027,254,851.22
39202	Хуримтлагдсан элэгдэл	(321,445,539.51)	(484,844,735.03)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	631,863,916.59	572,267,903.66
39206	Хуримтлагдсан элэгдэл	(467,321,786.12)	(427,170,853.50)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	192,538,394.81	216,244,161.04
39208	Хуримтлагдсан элэгдэл	(137,879,331.48)	(146,016,266.82)
393	Биет бус хөрөнгө	796,920,000.00	794,370,000.00
39301	Програм хангамж	14,807,313.00	14,807,313.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(9,407,313.00)	(11,957,313.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	791,520,000.00	791,520,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,978,523,917.14	5,802,313,076.62
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,978,523,917.14	5,802,313,076.62
51	Засгийн газрын хувь оролцоо	5,978,523,917.14	5,802,313,076.62
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,225,229,196.90	2,225,229,196.90
51101	Өмч: - төрийн	1,433,709,196.90	1,433,709,196.90
512	Хуримтлагдсан үр дүн	(679,513,386.31)	(855,724,226.83)
51210	Өмнөх үеийн үр дүн	(679,513,386.31)	(679,513,386.31)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(175,631,436.88)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,432,808,106.55	4,432,808,106.55
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,978,523,917.14	5,802,313,076.62

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ГҮЙЦЭТГЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,335,765,818.88	3,299,219,509.99
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	294,164,118.88	135,097,466.35
120	Нийтлэг татварын бус орлого	294,164,118.88	135,097,466.35
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	294,164,118.88	135,097,466.35
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,666,700.00	655,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,107,900.00	472,300.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	277,389,518.88	133,970,166.35
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,041,601,700.00	3,164,122,043.64
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,906,092,000.00	3,015,784,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	2,906,092,000.00	3,015,784,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	25,872,100.00	31,575,743.64
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	21,750,000.00	279,600.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	828,800.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	222,000.00	31,219,143.64
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,071,300.00	77,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	109,637,600.00	116,761,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	109,637,600.00	116,761,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,230,894,754.49	3,475,430,350.51
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,230,894,754.49	3,475,430,350.51

Орхон аймгийн 4 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,132,955,137.12	3,305,762,207.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,444,727,113.00	2,489,755,843.00
210101	Үндсэн цалин	1,733,948,086.00	1,497,086,362.00
210102	Нэмэгдэл	519,576,618.00	807,188,256.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,228,130.00	3,710,800.00
210104	Урамшуулал	186,974,279.00	181,770,425.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	307,804,314.52	327,569,295.81
210201	Тэтгэврийн даатгал	212,804,801.41	236,314,236.03
210202	Тэтгэмжийн даатгал	23,825,353.57	23,668,739.97
210203	ҮОМШӨ-ний даатгал	19,033,362.84	18,602,351.29
210204	Ажилгүйдлийн даатгал	4,740,099.73	4,490,002.49
210205	Эрүүл мэндийн даатгал	47,400,696.97	44,493,966.03
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	90,661,485.13	91,491,838.09
210301	Гэрэл, цахилгаан	14,657,371.61	14,250,212.58
210302	Түлш, халаалт	53,693,439.98	50,465,855.13
210303	Цэвэр, бохир ус	22,310,673.54	26,775,770.38
2104	Хангамж, бараа материалын зардал	39,743,661.98	49,257,912.94
210401	Бичиг хэрэг	4,512,450.00	4,661,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,080,473.98	1,204,082.24
210404	Ном, хэвлэл	2,420,800.00	514,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	11,216,390.00	5,081,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	20,513,548.00	11,350,419.00
210408	Бараа материал акталсны зардал	-	26,446,611.70
2105	Нормативт зардал	3,035,150.00	3,662,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	893,750.00	1,463,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,141,400.00	2,198,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,122,340.00	96,505,494.00
210604	Урсгал засвар	15,122,340.00	96,505,494.00
2107	Томилт, зочны зардал	828,800.00	127,200.00
210702	Дотоод албан томилт	828,800.00	127,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,532,300.00	589,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	72,300.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,460,000.00	589,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	229,499,972.49	246,803,523.17
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,461,000.00	852,150.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	25,252,168.40	22,168,696.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	201,786,804.09	223,782,677.17
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	97,939,617.37	169,668,143.50
2132	Бусад урсгал шилжүүлэг	72,854,966.00	143,508,100.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	68,506,800.00	137,095,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,348,166.00	6,412,400.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	579,403.64
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	579,403.64
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	12,734,914.87	16,298,261.91
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,734,914.87	16,298,261.91
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	12,349,736.50	9,282,377.95
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,349,736.50	9,282,377.95
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	104,871,064.39	(176,210,840.52)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	7,215,625.34	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	5,615,625.34	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	1,600,000.00	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(7,215,625.34)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	97,655,439.05	(176,210,840.52)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,225,229,196.90	4,432,808,106.55	(777,168,825.36)	5,880,868,478.09
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,225,229,196.90	4,432,808,106.55	(777,168,825.36)	5,880,868,478.09
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	97,655,439.05	97,655,439.05
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,225,229,196.90	4,432,808,106.55	(679,513,386.31)	5,978,523,917.14
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,225,229,196.90	4,432,808,106.55	(679,513,386.31)	5,978,523,917.14
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,225,229,196.90	4,432,808,106.55	(679,513,386.31)	5,978,523,917.14
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(176,210,840.52)	(176,210,840.52)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,225,229,196.90	4,432,808,106.55	(855,724,226.83)	5,802,313,076.62

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ГҮЙЦЭТГЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	3,099,890,817.00	3,188,471,156.23
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	16,774,600.00	4,361,800.00
120	Нийтлэг татварын бус орлого	16,774,600.00	4,361,800.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	16,774,600.00	4,361,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,666,700.00	655,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,107,900.00	3,706,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,083,116,217.00	3,184,109,356.23
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,906,092,000.00	3,015,784,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	2,906,092,000.00	3,015,784,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	25,872,100.00	32,491,203.64
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	21,750,000.00	279,600.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	828,800.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	222,000.00	32,134,603.64
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,071,300.00	77,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	109,637,600.00	116,761,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	109,637,600.00	116,761,500.00
1330	Төсвийн захирагчдаас	-	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	41,514,517.00	19,071,852.59
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	41,514,517.00	19,071,852.59
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	3,087,300,817.00	3,186,325,556.23
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,087,300,817.00	3,186,325,556.23
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,946,931,222.63	2,990,168,160.14
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,444,727,113.00	2,489,755,843.00
210101	Үндсэн цалин	1,690,649,386.10	1,639,857,981.10
210102	Нэмэгдэл	570,937,859.90	657,245,799.10
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,337,207.00	5,576,148.00
210104	Урамшуулал	176,802,660.00	187,075,914.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	307,804,314.52	327,569,295.81
210201	Тэтгэврийн даатгал	212,804,801.41	236,314,236.03
210202	Тэтгэмжийн даатгал	23,825,353.57	23,668,739.97
210203	ҮОМШӨ-ний даатгал	19,033,362.84	18,602,351.29
210204	Ажилгүйдлийн даатгал	4,740,099.73	4,490,002.49
210205	Эрүүл мэндийн даатгал	47,400,696.97	44,493,966.03
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	90,661,485.13	91,491,838.09
210301	Гэрэл, цахилгаан	14,657,371.61	14,250,212.58
210302	Түлш, халаалт	53,693,439.98	50,465,855.13
210303	Цэвэр, бохир ус	22,310,673.54	26,775,770.38
2104	Хангамж, бараа материалын зардал	49,132,939.98	27,067,089.24
210401	Бичиг хэрэг	5,099,950.00	7,573,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,080,473.98	1,204,082.24
210404	Ном, хэвлэл	7,298,700.00	2,745,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	14,147,579.00	4,535,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	21,506,237.00	11,008,507.00
210408	Бараа материал акталсны зардал	-	-
2105	Нормативт зардал	4,431,550.00	5,228,850.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,031,650.00	1,915,750.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,399,900.00	3,313,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,586,340.00	28,290,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	380,000.00	3,750,000.00
210604	Урсгал засвар	15,206,340.00	24,540,500.00
2107	Томилолт, зочны зардал	828,800.00	127,200.00
210702	Дотоод албан томилолт	828,800.00	127,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,532,300.00	589,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	72,300.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,460,000.00	589,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32,226,380.00	20,048,444.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,461,000.00	852,150.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	29,765,380.00	19,196,294.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	140,369,594.37	196,157,396.09
2132	Бусад урсгал шилжүүлэг	114,369,483.00	161,379,952.59
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	41,514,517.00	19,071,852.59
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	68,506,800.00	137,095,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,348,166.00	5,212,400.00

Орхон аймгийн 4 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	3,234,500.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	3,234,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	13,650,374.87	22,260,565.55
213305	Төвлөрүүлэх шилжүүлэг		579,403.64
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,650,374.87	21,681,161.91
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	12,349,736.50	9,282,377.95
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,349,736.50	9,282,377.95
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	12,590,000.00	2,145,600.00
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	12,590,000.00	3,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	12,590,000.00	3,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	12,590,000.00	3,000,000.00
223001	Бусад хөрөнгө	12,590,000.00	3,000,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(12,590,000.00)	(3,000,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	(854,400.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	854,400.00	854,400.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	854,400.00	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,136,273,500.00	3,108,092,960.14
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,136,273,500.00	3,105,092,960.14
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,995,017,300.00	2,963,839,260.14
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,498,859,800.00	2,489,755,843.00
210101	Үндсэн цалин	1,554,035,900.00	1,639,857,981.10
210102	Нэмэгдэл	755,333,300.00	657,245,799.10
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,697,000.00	5,576,148.00
210104	Урамшуулал	181,793,600.00	187,075,914.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	329,982,900.00	327,569,295.81
210201	Тэтгэврийн даатгал	230,028,500.00	236,314,236.03
210202	Тэтгэмжийн даатгал	24,988,600.00	23,668,739.97
210203	ҮОМШӨ-ний даатгал	19,990,900.00	18,602,351.29
210204	Ажилгүйдлийн даатгал	4,997,700.00	4,490,002.49
210205	Эрүүл мэндийн даатгал	49,977,200.00	44,493,966.03
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	107,789,500.00	91,491,838.09
210301	Гэрэл, цахилгаан	20,767,600.00	14,250,212.58
210302	Түлш, халаалт	60,046,900.00	50,465,855.13
210303	Цэвэр, бохир ус	26,975,000.00	26,775,770.38
2104	Хангамж, бараа материалын зардал	22,853,000.00	22,823,289.24
210401	Бичиг хэрэг	5,500,800.00	5,900,600.00
210402	Тээвэр, шатахуун		
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,861,900.00	1,204,082.24
210404	Ном, хэвлэл	4,620,700.00	2,745,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,560,300.00	3,652,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,309,300.00	9,320,507.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		
2105	Нормативт зардал	5,264,500.00	5,228,850.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,926,800.00	1,915,750.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,337,700.00	3,313,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,972,000.00	8,971,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,000,000.00	-
210604	Урсгал засвар	8,972,000.00	8,971,400.00
2107	Томилолт, зочны зардал	130,800.00	127,200.00
210702	Дотоод албан томилолт	130,800.00	127,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	598,700.00	589,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	598,700.00	589,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,566,100.00	17,282,444.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	859,500.00	852,150.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	16,706,600.00	16,430,294.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	141,256,200.00	141,253,700.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	141,256,200.00	141,253,700.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	137,095,700.00	137,095,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,160,500.00	4,158,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	3,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	3,000,000.00
223001	Бусад хөрөнгө	-	3,000,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,135,414,000.00	3,108,092,960.14

Орхон аймгийн 4 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,014,925,300.00	3,006,502,422.05
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	3,014,925,300.00	3,006,502,422.05
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	116,761,500.00	100,463,238.09
132001	Орон нутгийн төсвөөс	116,761,500.00	97,463,238.09
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	3,727,200.00	1,127,300.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	655,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,727,200.00	472,300.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		854,400.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Орхон аймгийн 4 дүгээр сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Буян-Ундрах гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхон аймгийн 4 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 17 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Орхон аймгийн 4 дүгээр сургууль нь дараах чиг үүргийг хэрэгжүүлдэг. Үүнд:

- Бүрэн дунд боловсрол олгох.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль,
- Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол.
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар батлагдсан Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхон аймгийн 4 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт орлогын 3,299,219.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 32,992.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 23,094.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

Орхон аймгийн 4 дүгээр сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 176,210.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, үндсэн хөрөнгө, бараа материалын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	854.4	-	(854.4)
Авлага	6,940.7	11,408.1	4,467.4
Бараа материал	248,798.3	238,799.9	(9,998.4)
Үндсэн хөрөнгө	5,721,930.5	5,552,105.1	(169,825.4)
Нийт хөрөнгө	5,978,523.9	5,802,313.1	(176,210.8)
Засгийн газрын хувь оролцоо	5,978,523.9	5,802,313.1	(176,210.8)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	5,978,523.9	5,802,313.1	(176,210.8)

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 854.4 мянган төгрөгөөр буурсан нь ахмадын сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс тайлант онд зарцуулснаас шалтгаалжээ.

Авлагын эцсийн үлдэгдэл 11,408.1 мянган төгрөг нь 2021-2022 оны хичээлийн жилд хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн зарцуулагдаагүй зардлын үлдэгдэл юм.

Бараа материалын дансны үлдэгдэл 238,799.9 мянган төгрөг болж 9,998.4 мянган төгрөгөөр буурсан нь 26,446.6 мянган төгрөгийн бараа материал акталсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 5,552,105.1 мянган төгрөг болж 169,825.4 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант оны 29,875.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж үнэ төлбөргүй хүлээн авсан хэдий ч элэгдлийн зардал 223,782.7 мянган төгрөг тул үндсэн хөрөнгийн данс буурсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 3,716,696.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 3,716,696.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 580,423.1 мянган төгрөгөөр бууруулж, орон нутгийн төсвөөс 3,136,273.5 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр тусгай зориулалтын шилжүүлгээр 3,136,273.5 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс олгохоор төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 3,136,273.5 мянган төгрөгийн санхүүжилт олгож, орон нутгийн төсөвт 31,180.5 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,105,092.6 мянган төгрөг буюу 99.01 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд 32,491.2 мянган төгрөг орсныг зориулалтын дагуу зарцуулсан байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудит хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тус газрын санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллийг хугацаандаа оруулж, мэдээлсэн байна. Мөн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 29 гүйлгээг бүрэн мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар итгэл үзүүлсэн байна.

3.11 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ

Орхон аймгийн 4 дүгээр сургуулийн санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгөн шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй ба дараагийн аудитаар нэмэлт санхүүжилтийн дансыг үзэх.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 4,994.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 579.4 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,807.5 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 2,607.4 мянган төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Тайлант онд 579.4 мянган төгрөгийн авлагыг илүү бүртгэсэн байна.

4.2 Төлбөрийн акт

1. Сургуулийн захирал нь ээлжийн амралттай байх хугацаандаа 10 хоногийн 792,510 төгрөгийн цалинг давхардуулан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 5.1.3-д “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 16.5.3-д “батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтыг аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага хэрэгжүүлнэ” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

2. Аудитаар бараа материалын дансанд тооллого хийхэд 1,015.0 мянган төгрөгийн аж ахуйн материал дутаж байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална:", 5.1.4-д "үнэн зөв байх;", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", 20.2.9-д "аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах;" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Урсгал зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс худалдан авах зардлаас компьютерын дэлгэц засуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41.2.2-д "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах;", Сангийн сайдын 2018 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 134 дүгээр тушаалаар батлагдсан Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журмын 3.1.6-д "Төсвийн тухай хуулийн 42.4-т заасны дагуу дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлийг албан бичгээр авсан байх." гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргаж, зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулахдаа эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авч байх.

2. Урсгал зардлын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Ахмадын сангаас тус сургуулийн ахмад ажилтануудад тус бүр нь 40.0 мянган төгрөгийн түлээ, нүүрсний хөнгөлөлт үзүүлэхдээ 1 ахмад ажилтанд 5600 төгрөг дутуу олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Хамтын гэрээ болон дотоод журамд заасан тусламж, дэмжлэгийг олгохдоо батлагдсан төсөвтөө багтаан тэгш хуваарилж байх.

3. Бараа материалын данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Тайлант онд худалдан авсан байгууллагын ажил үйлчилгээнд түгээмэл хэрэглэгддэг хувин, гишгүүр, хогийн сав зэрэг 1 жилээс дээш тайлангийн хугацааны туршид ашиглагдахаар хүлээгдэж буй бараа материалын шинжтэй зүйлсийг шаардах хуудсаар шууд зарлагадсан байна.

Өгсөн зөвлөмж:

Байгууллагын ажил үйлчилгээнд түгээмэл хэрэглэгддэг 1 жилээс дээш тайлангийн хугацааны туршид ашиглагдахаар хүлээгдэж буй бараа материалын шинжтэй зүйлсийг аж ахуйн болон тусгай зориулалтын материалын үлдэгдлээр тайлагнаж байх.

4. Урсгал зардлын данстай холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

Албан хаагчийн унааны нэмэгдлийг албан томилолтоор ажилласан хугацаанд давхардуулан олгосон байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 61.1.3-д "гүйцэтгэж байгаа албан үүргийн шинж байдлаас хамааран зохих журмын дагуу албаны унаа хэрэглэх, ажилдаа ирэх, буцах төрийн тээврийн хэрэгслийн зардлын зохих хэсгийг нөхөн авах"; Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журам"-ын 2.2-д "Албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр дараах зардлаас бүрдэнэ:"; 2.2.1-д "унааны зардал"; 2.2.2-д "байрны зардал"; 2.2.3-д "хоолны зардал."; 8.4-д "Төрийн албан хаагчийн өдрийн хоолны зардлын тодорхой хэсгийг байгууллагаас нөхөн олгоно." гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Албан хаагчийн унааны нэмэгдлийг албан томилолтоор ажилласан хугацаанд давхардуулан олгохгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Орхон аймгийн 4 дүгээр сургууль	7	4,994.3	1	579.4	2	1,807.5	0	0	4	2,607.4
Дүн		7	4,994.3	1	579.4	2	1,807.5	0	0	4	2,607.4